

**УЛААНБААТАР ХОТЫН ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ТЕЛЕВИЗҮҮДИЙН
2023 ОНЫ 2 ДУГААР УЛИРАЛД НЭВТРҮҮЛСЭН ТАНИН МЭДЭХҮЙН
НЭВТРҮҮЛГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН ДҮГНЭЛТ**

Өргөн нэвтрүүлгийн тухай хууль, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 01 тоот тогтоолоор батлагдсан “Телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлага”-аар Монгол улсад хамрах хүрээтэй Улаанбаатар хотын өргөн нэвтрүүлгийн телевиз нь жилд 180 цагаас багагүй танин мэдэхүйн нэвтрүүлэг бэлтгэн нэвтрүүлэх үүрэг хүлээлгэдэг. Зохицуулах хорооноос телевизүүдийн хөтөлбөрт хийдэг байнгын хяналт, мониторингийн тайланд үндэслэн улирал тутам дээрх үүргийн хэрэгжилтийн байдалд үнэлгээ дүгнэлт гарган ажиллаж байна.

Улаанбаатар хотын өргөн нэвтрүүлгийн телевизүүдийн 2023 оны 2 дугаар улиралд нэвтрүүлсэн Танин мэдэхүйн нэвтрүүлгийн хяналт, мониторингийн дүн дараах байдалтай байна.

Цаг:мин:сек

Телевизийн нэр	Танин мэдэхүйн нэвтрүүлэг			Нийт
	2023 он 4 сар	2023 он 5 сар	2023 он 6 сар	
TenGer	134:31:17	114:58:27	58:44:05	308:13:49
25-р суваг	61:10:03	48:34:41	49:05:13	158:49:57
Ийгл ньюс	46:55:54	43:44:43	41:56:15	132:36:52
Central	34:22:26	42:47:51	48:48:31	125:58:48
ETB	43:11:48	29:51:28	30:15:47	103:19:03
NTV	9:15:47	25:40:42	18:33:44	53:30:13
Боловсрол суваг	20:13:31	11:09:58	14:48:02	46:11:31
ТМ	11:39:44	11:20:58	18:42:41	41:43:2
ТВ8	7:45:03	9:10:03	14:36:25	31:31:31
Сүлд	11:12:37	9:50:14	6:10:26	27:13:17
ТВ5	9:44:15	9:56:02	6:52:18	26:32:35
UBS	3:13:14	11:30:48	7:45:16	22:29:18
Стар	6:36:34	6:00:10	5:26:36	18:03:20
Монгол	8:44:22	6:29:28	0:43:26	15:57:16
С1	1:56:23	2:58:32	7:23:11	12:18:06
ТВ9	4:46:49	3:15:54	1:39:57	9:42:40
SBN	2:29:06	2:32:47	2:01:44	7:03:37
Малчин	2:00:07	1:49:28	1:44:43	5:34:18
Нийт	419:49:00	391:42:14	335:18:20	1146:49:34

Хүснэгтээс харахад 2023 оны 2 дугаар улирлын байдлаар TenGer, 25-р суваг, Ийгл ньюс, Central, ETB, NTV, Боловсрол суваг, ТМ телевизүүдийн танин мэдэхүйн нэвтрүүлэг нэвтрүүлсэн явц хангалттай хэмжээнд байна. Харин ТВ8, Сүлд, ТВ5, UBS телевизүүд үлдсэн хугацаанд нэмэгдүүлбэл шаардлага хангах хэмжээнд хүргэх боломжтой бол Стар, Монгол, С1, ТВ9, SBN, Малчин телевизүүд танин мэдэхүйн нэвтрүүлгээ нэмэгдүүлэхгүй бол жилийн эцсийн дүнгээр хөтөлбөрт тавигдах шаардлагад заасан 180 цагийн шаардлагыг хангахгүй байж болзошгүй харагдаж байна.

**ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ТЕЛЕВИЗҮҮДИЙН ТАНИН МЭДЭХҮЙН
НЭВТРҮҮЛЭГ НЭВТРҮҮЛСЭН БАЙДАЛ**
(2023 ОНЫ I, II УЛИРЛЫН ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ)

Цаг:мин:сек

Телевизийн нэр	Танин мэдэхүйн нэвтрүүлэг		
	2023 оны I улирал	2023 оны II улирал	2023 оны хагас жилийн дүн
TenGer	272:09:01	308:13:49	580:22:50
Ийгл ньюс	127:00:43	132:36:52	259:37:35
25-р суваг	51:36:30	158:49:57	210:26:27
ЕТВ	82:24:32	103:19:03	185:43:35
Central	72:47:45	125:58:48	198:46:33
Боловсрол суваг	79:14:25	46:11:31	125:25:56
ТМ	31:13:55	41:43:23	72:57:18
NTV	10:51:10	53:30:13	64:21:23
Сүлд	21:22:15	27:13:17	48:35:32
TB9	30:40:51	9:42:40	40:23:31
Монгол	21:47:20	15:57:16	37:44:36
TB8	12:31:41	31:31:31	44:03:12
TB5	8:01:01	26:32:35	34:33:36
С1	22:32:05	12:18:06	34:50:11
Стар	14:01:45	18:03:20	32:05:05
UBS	2:24:06	22:29:18	24:53:24
SBN	5:12:07	7:03:37	12:15:44
Малчин	2:07:39	5:34:18	7:41:57
Нийт	867:58:51	1146:49:34	2014:48:25

Телевизүүдийн 2023 оны II улиралд танин мэдэхүйн нэвтрүүлэг нэвтрүүлсэн дүн мөн оны I улиралд нэвтрүүлсэн дүнгээс 32%-аар өссөн үзүүлэлттэй байгаа нь TenGer, Ийгл ньюс, 25-р суваг, ЕТВ, Central телевизүүдийн танин мэдэхүйн нэвтрүүлгийн цаг өссөнтэй холбоотой байна. Түүнчлэн ТМ, NTV, TB8, TB5, UBS телевизүүдийн нэвтрүүлсэн танин мэдэхүйн нэвтрүүлгийн цаг энэ оны 2-р улиралд өмнөх улиралтай харьцуулахад өссөн ч хагас жилийн дүнгээр хараахан шаардлага хангахгүй үзүүлэлттэй байна. Тиймээс эдгээр телевизүүд үлдсэн хугацаанд энэ төрлийн нэвтрүүлгийн цагаа нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Доор 2023 оны хагас жилийн үзүүлэлтийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулан авч үзье.

Телевизийн нэр	2022 хагас жил	2023 хагас жил
TenGer	113:12:45	580:22:50
Ийгл ньюс	99:02:39	259:37:35
25-р суваг	175:12:11	210:26:27
Central ТВ	301:57:01	198:46:33
ЕТВ	161:33:24	185:43:35
Боловсрол суваг	531:12:52	125:25:56
ТМ	88:24:46	72:57:18
NTV	40:52:57	64:21:23
Сүлд	114:27:35	48:35:32
TB8	36:26:37	44:03:12

ТВ9	69:30:31	40:23:31
Монгол HD	13:26:21	37:44:36
С1	59:52:28	34:50:11
ТВ5	97:32:47	34:33:36
Стар ТВ	32:30:03	32:05:05
UBS	64:38:31	24:53:24
SBN	21:28:48	12:15:44
Малчин ТВ	346:08:24	7:41:57
Нийт	2367:30:40	2014:48:25

Дээрх хүснэгтээс харахад энэ оны хагас жилийн дүнгээр буурсан үзүүлэлттэй байгаа нь Малчин телевизийн танин мэдэхүйн нэвтрүүлэг нэвтрүүлсэн цаг багагүй хэмжээгээр буурсан байгаатай холбоотой байна.

Арилжааны телевизүүдэд заавал танин мэдэхүйн нэвтрүүлэг нэвтрүүлэх шаардлага тавьдаггүй болно.

--oOo--